



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/650

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Мөрөн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хүнсний эрүүл ахуй, электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулж байгаа худалдаа үйлчилгээний төв, дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийх, аймгийн Засаг даргын 2023 оны А/268 дугаар захирамжийн хэрэгжилт үр дүнг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хяналт шалгалтын ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, нөхцөл байдалтай нэг бүрчлэн танилцаж, хяналт шалгалтын болон захирамжийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг салбар зөвлөлийн IV хуралдаанд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны.....
дугаар сарын.....-ны өдрийн
.....дугаар захирамжийн хавсралт

**МӨРӨН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭНД ХҮНСНИЙ
ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН ЭЛЕКТРОН ТАМХИ, ТҮҮНИЙ ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙГ
ХУДАЛДАН БОРЛУУЛЖ БУЙ ГАЗРУУДАД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Гишүүд:

М.Үүрийнбаяр- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Д.Мөнхжаргал- Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
О.Бадраа – Аймгийн Боловсролын газрын дарга
Н.Хонгорзул – Аймгийн Боловсролын газрын боловсролын хяналтын улсын
байцаагч
Ю.Одгэрэл – Аймгийн Цагдаагийн газрын хошууч, хүүхдийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн
М.Баасандалай – Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар
стандартын хяналтын улсын байцаагч
А.Үүрийнцолмон – Аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн
дарга, хяналтын улсын ахлах байцаагч
С.Отгонжаргал- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого хариуцсан
мэргэжилтэн
Д.Золжаргал– Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
Шударга өрсөлдөөн, хууль зүйн салбар дундын асуудал
хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга:

Ч.Дашбаяр- Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга